

“САВ БАГЛАА БООДОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл										
1.	“Сав, баглаа боодол” Үндэсний хөтөлбөр, 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 287 дугаар тогтоол	Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.										
2.	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл, ХХААХҮЯ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, МХЕГ, СХГ, ШӨХТГ, ГЕГ, ГХЯ, СЯ, ХЗДХЯ, ЗТХЯ, ЖДҮХС, Аймаг, Нийслэлийн ЗДТГ										
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх; Зорилт 2. хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах; Зорилт 3. сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх.										
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)										
		Үүнд:	Төсөв сая төг.			Гүйцэтгэл, сая төгрөг			Хувь, %			
			2017	2018	2019	2017	2018	2019	2017	2018	2019	
			Зорилт 1									
			Зорилт 2			10,0	10,0		10,0	10,0		100
Зорилт 3												
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт: 1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжсэн хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна	Биелэлт: Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолоор сав, баглаа боодлын үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын гаалийн албан татвараас чөлөөлсөн бөгөөд тогтоолын хэрэгжилт 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой холбогдуулан сунгуулах саналыг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн. Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2017 онд баталсан ба хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, тайлагнах, энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах, булшлах, тайлагнах асуудлыг зохицуулсан. 2018 оны 09-11 дүгээр саруудад сав, баглаа боодлын стандартчилал, техникийн зохицуулалтын чиглэлээр Монгол улсад батлагдан, мөрдөгдөж буй нийт 62 стандартын шинжлэх ухаан, техникийн түвшинд үнэлгээ хийсэн бөгөөд Европын Холбооны Стандартчилалын байгууллага (CEN), Олон улсын Стандартчилалын байгууллага (ISO)-ын 112 стандарт (олон улсын 51, бүс нутгийн 54, байгууллагын б)-ын жагсаалтыг гаргаж, Монгол улсад нутагшуулах тухай саналыг СХЗГ-т хүргүүлсэн болно. Мөн “Баяжмалыг савлах, тээвэрлэх зориулалттай хүнд даацын шуудай” техникийн ерөнхий шаардлага, “Хүнсний зориулалтын хуванцар сав”										

		<p>стандартуудын төслийг 2018 онд шинээр боловсруулсан. Эдгээр стандартыг 2019 онд батлуулна.</p> <p>Үндэсний уламжлалт сав баглаа болох ширэн хөхүүр, модон хувингийн стандарт боловсруулах санал боловсруулж СХЗГ-т хүргүүлэв. Стандартын төслүүдийг 2019 онд батлуулна.</p> <p>Засгийн газрын “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрт сав, баглаа боодлын захиалгын болон худалдааны цэгийг байгуулж ажиллуулах талаар тодорхой зорилт тусгав.</p> <p>“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах чиг үүрэгтэй орон тооны бус Үндэсний зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮ-ийн Сайдын А/138 тушаалаар батлуулж, анхны хуралдаанаар 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлсэн.</p> <p>Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2017 оны 11 сард гадаадын донор, олон улсын байгууллагын 100 гаруй төлөөлөгчдийг оролцуулан олон улсын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, “Сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх”, “Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав”, “Уламжлалт сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих”, “Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” гэсэн 5 төслийн баримт бичгийг танилцуулсан.</p>
	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Хүнсний сав, баглаа боодолд тавих эрүүл ахуйн шаардлагыг тодорхой болгох Хүрэх үр дүн 2: Бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодолтой харьцах хэрэглэгчдийн хандлага, сонголт өөрчлөгдөж, мэдлэг нэмэгдсэн байх Хүрэх үр дүн 3: Зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээ буурсан байх</p>	<p>1. Хүнсний зориулалтаар ашиглагдаж буй хуванцар савны материалыг шинжлэх, эрсдлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын гэмдэглэгээг зориулалтын саванд хэрэглэх асуудлаар МХЕГ-ын ХАБҮЛЛ, НЭМҮТ-ийн Хор судлал, орчны шинжилгээний төв, ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэн, АШУҮИС, “САМО” институт, ШУТИС, ГТЛ-ийн саналыг тусган, “Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” төслийн баримт бичгийг 2018 онд боловсруулав.</p> <p>2006 онд батлагдсан “Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5684 - 2006 стандартыг шинэчлэх, “Хүнсгүй харьцах гадаргууд зориулагдсан материалыг таних тэмдгийн Үндэсний стандарт”-ыг боловсруулах, батлуулах, Европын Холбооны стандартчилалын Хорооноос баталсан EN 1186-1-15 :2002 серийн 17 стандарт, EN 13130-1:2004 серийн 28 стандартыг хувилж, олшруулах зөвшөөрөл, түүнийг орчуулах, үндэсний стандартаар батлуулах зөвлөх үйлчилгээний худалдан авалтын талаарх саналыг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэв.</p> <p>2. Хүнсний зориулалтын бус хуванцар сав хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлдөг тухай богино хэмжээний анимейшнийг 2018 онд бүтээж, цахим мэдээллийн сувгаар олон нийтэд сурталчилж байна.</p> <p>2018 онд “Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав” төслийг Туркийн Засгийн газарт тавьсан боловч, хасагдсан.</p> <p>МҮХАҮТ, Монголын хүнсчдийн холбооноос гаргаж буй хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн хэрэгцээ</p>

	<p>шаардлагын судалгаанд үндэслэн Хөгжлийн банкны дэргэдэх “DBM лизинг” ХХК-иас дээрх тээврийн хэрэгслийг худалдан авахад хөнгөлөлттэй зээл авах механизмыг бүрдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>ЭМЯ, ХХААХҮЯ-наас зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, зориулалтын савны ач холбогдлын талаарх сурталчилгааны зөвлөмж материал 10000 хувь хэвлүүлж, Нийслэл болон орон нутгийн хэрэглэгчдэд тарааж, сурталчлав.</p> <p>3. “Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулах талаар ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2017-2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгуулсан. Тус ажлын хүрээнд орон нутагт хөх савны хор хөнөөл, хүнсний зориулалтын савны хэрэглээний талаар орон нутагт нийт 88 удаагийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, 15 мянга гаруй хүнийг хамруулан, сурталчилгааны материал тараасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сүхбаатар аймагт “Аргил сувд” ХХК-иас 1300 ширхэг усны эко сав татан авч, Баруун-Урт сумын 400 гаруй иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулсан. • Говь-Алтай аймагт хүнсний зориулалтын бус хуванцар хөх савны хэрэглээг сургууль, цэцэрлэгүүдэд бүрэн халсан. • Хэнтий аймагт 24 худаг, уст цэг болон хүнсний 120 дэлгүүрийн мэдээллийн самбарт “Хүнсний зориулалтын сав” түүний ач холбогдлын талаар танилцуулга, мэдээлэл байршуулж, олон нийтэд сурталчилсан. • Өмнөговь аймагт орон нутгийн төсвийн хүрээнд эко савалгаа нэвтрүүлэхэд нь зориулж “Задат” ХХК-нд 10 сая, “Ингэний сүүн чихэр” үйлдвэрлэлд 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. • Өвөрхангай аймгийн бүх суманд төсөвт байгууллагуудад хүнсний зориулалтын бус савыг хүнсэнд хэрэглэхээс татгалзаж хэвшсэн. • Завхан аймагт хуванцар савны худалдаа эрхлэгчдэд “Хуванцар савны эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээ” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ арга хэмжээний дүнд тус аймгийн зах зээлд хөх савны нийлүүлэлт 50 хувиар буурсан. • Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн үйлчилгээний газруудын гал тогоонд зориулалтын сав, суулга хэрэглэж хэвшсэн. • Төв аймгийн хэмжээнд судалгаа хийж, нийт 29 мянган өрхийн 60 хувь нь хүнсний зориулалтын бус сав хэрэглэж байна гэсэн дүн гарсан. Тус аймгийн 27 суманд сургалт зохион байгуулж 5890 өрхийг хамруулан, 3900 ширхэг гарын авлагаар хангасан. <p>Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар Монгол Улсын сав, баглаа боодол үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн анхдугаар зөвлөлдөх уулзалт-2018 болон сав, баглаа боодлын салбарын оны шагнал “Мөнгөн богц” гардуулах арга хэмжээний үеэр хэвлэлийнхэнд хандаж мэдээлэл хүргэсэн. Мөн сав, баглаа боодлын үйлдвэрлэл, хэрэглээний асуудлаар ТВ-8, “V” ТВ, Монголын радиогийн нэвтрүүлгүүдэд оролцож ярилцлага, мэдээлэл өгөв.</p>
--	---

		Хүнсний зориулалтын бус хуванцар савны хор нөлөөг олон нийтийн анхаарлын төвд оруулах, сав, баглаа боодлын салбарыг сурталчлах, бэхжүүлэх зорилгоор “Сав, баглаа боодлын өдөр”-тэй болох зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал авч нэгтгэн 2018 оны 3 дугаар сард, мөн 7 дугаар сард ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч ХЗДХЯ-наас дэмжих боломжгүй гэсэн санал ирүүлсэн үндэслэлээр буцаасан.
	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Сав, баглаа боодол, хаяг шошгын дотоодын үйлдвэрлэл, хангамжийн хэмжээ нэмэгдсэн байх	<p>Дотоодын сав, баглаа боодлын үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл, байдлын шинжилгээг 2017 онд хийж гүйцэтгэн, Монгол Улсын дотоодын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн каталогийг боловсруулж 1000 ш хэвлүүлэн, түгээж байна.</p> <p>Уламжлалт модон сав үйлдвэрлэгч “ТЭББЭ” ХХК-нд ЖДҮХС-гийн 280.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд шил үйлдвэрлэх төслийг Хөгжлийн банкинд танилцуулсныг 2019 онд тус банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.</p> <p>Даацын шуудай, сав баглаа боодол үйлдвэрлэгч дотоодын 7 үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, тэдгээрийн суурилагдсан хүчин чадал, хүчин чадлын ашиглалт, мөн хэрэгцээний харьцуулсан судалгааг гаргаж, төрийн худалдан авалтад нэгдсэн зохион байгуулалттай, кластер хэлбэрээр оролцох асуудлаар санал, мэдээлэл солилцсон. Мөн Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн холбооноос Хөгжлийн банкинд сав, баглаа боодлын салбарт хэрэгжүүлэх кластер төслийн саналыг хүргүүлэв.</p> <p>Гишүүнээр элсэх, техникийн туслалцаа авах асуудлаар Дэлхийн сав, баглаа боодлын байгууллага /World Packaging Organization/-тай холбоо тогтоон ажиллаж байна.</p> <p>“Намрын ногоон өдрүүд-2017” нэгдсэн арга хэмжээний “Эрүүл Монгол хүнс” үзэсгэлэн худалдаанд “Дэвшилтэт савлагаатай хүнсний бүтээгдэхүүн”-ий номинацийн шалгаруулалтыг зохион байгуулсан. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн олон улсын зөвлөлдөх уулзалтын үеэр дотоодын 10 гаруй сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэнг зохион байгуулсан. Мөн “ТЭББЭ” ХХК-ийн модон савны талаар нэвтрүүлэг хийж, “Сүлд” ТВ-ээр 2 удаагийн цацалт хийсэн. Монгол Улсын сав, баглаа боодол үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 12 дугаард зохион байгуулж “Мөнгөн богц” шагналыг хүнс, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоол, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын тус бүр 1, нийт 5 аж ахуйн нэгжид олгож, үндэсний үйлдвэрлэгчдийг урамшуулав.</p>
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p><u>Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал:</u></p> <p>1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах, дотоодын сав, баглаа боодлын үйлдвэрлэл хөгжүүлэх зорилго бүхий тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлснээрээ баглаа боодол үйлдвэрлэл эрхлэгчдэд эрх зүйн үндэслэл олгосон.</p> <p>2. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй сав баглаа боодлын талаарх мэдээлэл олон нийт тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон.</p> <p><u>Дутагдалтай тал:</u></p>

		<p>1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл нь санхүүжилтийн хязгаарлагдмал байдал болно.</p> <p>2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл, ХХААХҮЯ оролцогч талуудын уялдааг хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авах тал дээр санаачлага дутагдалтай ажиллав.</p>				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл, ХХААХҮЯ</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, МХЕГ, СХГ, ШӨХТГ, ГЕГ, ГХЯ, СЯ, ХЗДХЯ, ЗТХЯ, ЖДҮХС, Аймаг, Нийслэлийн ЗДТГ -хамтын ажиллагаа, уялдаа сул</p>				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		57.6 %	3	50.0%	61.3 %	61.4 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ:				

“САВ БАГЛАА БООДОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /2018/

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилт	Үнэлгээ
Зорилт 1. хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх								
1	сав, баглаа боодол, хаяг шошго үйлдвэрлэх, тэдгээрийн хаягдлыг дахин боловсруулах зориулалт бүхий үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Хууль, тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт	Гаалийн татвараас чөлөөлөгдсөн тоног төхөөрөмжийн тоо, үнийн дүн	ХХААХҮЯ, СЯ	ХЗДХЯ, ТББ, ААН	2017-2021	Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар тогтоолоор “Гаалийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсийн жагсаалт”-ыг батлуулсан. Уг тогтоолын хүрээнд сав, баглаа боодлын үйлдвэрийн импортоор авсан тоног төхөөрөмж гаалийн албан татвараас чөлөөлөгдсөн. Энэ тогтоолын хэрэгжилт 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой холбогдуулан сунгуулах саналыг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн.	70
2	сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа болон хуучин савны устгал, шилжилтийг хянах, бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;	Мэдээллийн сан	Бүртгэл, мэдээллийн сан үүссэн байх	ХХААХҮЯ БОАЖЯ	ГЕГ, МХЕГ, ТББ, ААН	2017-2021	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2017 оны 5 дугаар сарын 12-нд баталсан. Эрх зүйн орчны хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам, аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, үйл ажиллагааны тайлан болон энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагааны тайлангийн маягт боловсруулахаар тусгагдсан.	40
3	хүнсний зориулалтын бус саван дээр анхааруулах тэмдэглэгээ тавьдаг болох эрх зүйн зохицуулалт бий болгох;						Хүнсний зориулалтын бус саван дээр анхааруулах тэмдэглэгээ тавьдаг болох эрх зүйн зохицуулалт бий болгох асуудлыг судалж байна.	0
4	сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээг хамарсан техникийн	Техникийн зохицуулалт, нутагшсан болон	Нутагшсан болон шинэчлэгдсэн стандартын тоо	ХХААХҮЯ, СХЗГ	МХЕГ, ТББ, ААН	2017-2021	Сав, баглаа боодлын стандартчилал, техникийн зохицуулалтын өнөөгийн байдал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх ажлын уулзалтыг 2017 оны 9 дүгээр сард ХХААХҮЯ-нд зохион байгуулсан. Уулзалтад ЭМЯ, СХЗГ, МХЕГ болон холбогдох	40

	зохицуулалт гаргах, олон улсын стандартуудыг нутагшуулах, одоо мөрдөж байгаа стандартуудыг шинэчлэх;	шинэчлэгдсэн стандарт					төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөлөл оролцож, хамтран ажиллах талаар санал солилцсон. Стандартын 2018 оны улсын үзлэгийн хүрээнд үйлдвэрлэл, хаяг шошго, техникийн зохицуулалтын стандартыг дахин хянах, олон улсын түвшинд хүргэх, шинээр батлуулах стандартын саналыг боловсруулах ажлыг зохион байгуулж, одоо мөрдөгдөж буй нийт 62 стандартыг хянасан. Мөн “Баяжмалыг савлах, тээвэрлэх зориулалттай хүнд даацын шуудай” техникийн ерөнхий шаардлага, “Хүнсний зориулалтын хуванцар сав” стандартуудын төслийг 2018 онд шинээр боловсруулсан. Эдгээр стандартыг 2019 онд батлуулна. СХЗГ-тай хамтран уулзалт зохион байгуулж, сав баглаа боодлын үйлдвэрлэгчдэд Монгол Улсын стандартчиллын эрх зүйн орчны шинэчлэлийн талаар мэдээлэл хийв.	
5	улсын хилээр хүнсний зориулалтаар нэвтрүүлэхийг зөвшөөрсөн сав, баглаа боодол, ахуйн барааны жагсаалт гаргах, барааны ангиллын код тодорхойлох, батлуулах;	Жагсаалт, барааны код	Жагсаалт батлагдаж, барааны код тодорхойлсон байх	ХХААХҮЯ, ГЕГ	МХЕГ, ААН	2017-2021	Улсын хилээр хүнсний зориулалтаар нэвтрүүлэхийг зөвшөөрсөн сав, баглаа боодол, ахуйн барааны жагсаалт гаргах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж байна.	0
6	сав, баглаа, боодлын аюулгүй байдлыг хангах, хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжийн хөрөнгийг уг салбарт зарцуулахыг дэмжих.	Хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалт нэмэгдсэн байх	ХХААХҮЯ, СЯ, ГХЯ	ТББ, ААН	2017-2021	Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор ХХААХҮЯ-наас 2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр ГХЯ-нд олон улсын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтад ОХУ, Франц, Чех, Турк, Кувейт, Беларусь, Арабын Нэгдсэн Эмират, Болгар, Вьетнам улсын Элчин сайдын яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Дэлхийн банк, Мерси кор, Глобал коммунитис, Каритас Монгол зэрэг олон улсын байгууллага, манай улсад хэрэгжиж байгаа олон улсын хөтөлбөр, төслийн нэгжүүд, үндэсний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх яам, агентлагууд, төрийн бус	40

							байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 100 гаруй хүн оролцсон. Зөвлөлдөх уулзалтын үеэр гадаадын донор, олон улсын байгууллагуудад “Сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх”, “Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав”, “Уламжлалт сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих”, “Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” гэсэн 5 төслийн баримт бичгийг танилцуулсан. Сав, баглаа боодлын салбарт хөнгөлөлттэй санхүүжилт татах зорилгоор Хөгжлийн банкны холбогдох албан тушаалтнуудтай 2018 оны 2 дугаар сард уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд Хөгжлийн банкнаас сав, баглаа боодлын салбарыг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн бөгөөд Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн холбооноос сав, баглаа боодлын салбарт хэрэгжүүлэх кластер төслийн саналыг боловсруулахаар тогтсон. Уламжлалт модон сав үйлдвэрлэгч “ТЭББЭ” ХХК-нд ЖДҮХС-гийн 280.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Тус компани үйлдвэрлэлийн шугамаа өргөтгөсөн.	
--	--	--	--	--	--	--	---	--

Зорилт 2. Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах

1	хүнсний сүлжээний бүх үе шатанд ашиглах сав, баглаа боодол болон хүнстэй шууд харьцах үйлдвэрийн болон ахуйн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хаяг, шошгын зөрчлийг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх, уг үйл ажиллагаанд тавих төрийн болон дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх;	Сургалт, сурталчилгаа, хяналтын үйл ажиллагаа	Хаяг, шошгын зөрчил буурсан байх	МХЕГ	ААН	2017-2021	Хүнсний зориулалтын бус хуванцар савны хүний эрүүл мэнд хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх тухай богино хэмжээний анимейшн бүтээлийг 2018 онд гүйцэтгүүлж, олон нийтэд сурталчилгаа хийж байна. Хүнсний сүлжээний бүх үе шатанд ашиглах сав, баглаа боодол болон хүнстэй шууд харьцах үйлдвэрийн болон ахуйн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хаяг, шошгын зөрчлийг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх, уг үйл ажиллагаанд тавих төрийн болон дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх талаар ХХААХҮЯ-наас МХЕГ-тай 2019 онд хамтран ажиллана.	40
---	---	---	----------------------------------	------	-----	-----------	--	----

2	<p>сав, баглаа боодлын аюулгүй байдлыг хангах, хаяг шошгын бичлэг үнэн зөв эсэхийг баталгаажуулдаг болох, үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр түншлэгч орнууд, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлж, олон улсын сайн туршлагыг нутагшуулах;</p>	Төсөл	Төсөл хэрэгжсэн байх	ХХААХҮЯ	Олон улсын байгууллага, ТББ, ААН	2017-2021	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор ХХААХҮЯ-наас олон улсын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтад ОХУ, Франц, Чех, Турк, Кувейт, Беларусь, Арабын Нэгдсэн Эмират, Болгар, Вьетнам улсын Элчин сайдын яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Дэлхийн банк, Мерси кор, Глобал коммунитис, Каритас Монгол зэрэг олон улсын байгууллага, манай улсад хэрэгжиж байгаа олон улсын хөтөлбөр, төслийн нэгжүүд, үндэсний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх яам, агентлагууд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 100 гаруй хүн оролцсон. Тус зөвлөлдөх уулзалтад ХХААХҮЯ-наас “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн талаар, ЭМЯ-наас “Хүнсний зориулалтын бус савны хэрэглээ – хүний эрүүл мэнд” сэдвээр, БОАЖЯ-наас “Хуванцар сав – хог хаягдал – хүрээлэн буй орчин” сэдвээр, СХЗГ-наас “Хүнсний сав, баглаа боодол - стандартчилал” сэдвээр, МХЕГ-аас “Хүнсний сав, баглаа боодол – хяналт шалгалт” сэдвээр, ШӨХТГ-аас “Хүнсний сав, баглаа боодол – хэрэглэгчийн боловсрол” сэдвээр, “Заша өвс” НҮТББ болон Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбооноос “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ-ын оролцоо” сэдвээр тус бүр танилцуулга, мэдээлэл хийсэн. Зөвлөлдөх уулзалтын үеэр гадаадын донор, олон улсын байгууллагуудад “Сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх”, “Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав”, “Уламжлалт сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих”, “Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” гэсэн 5 төслийн баримт бичгийг танилцуулсан. “Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав төслүүдийг Туркийн Засгийн газрын дэмжлэгээр хэрэгжүүлэхээр 2018 онд санал тавьж байсан боловч эцсийн шатанд хасагдсан.</p>	40
---	--	-------	----------------------	---------	----------------------------------	-----------	--	----

3	хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж байгаа картонон хайрцаг, нэг удаагийн хэрэглээний хэрэгсэл болон ус, ундааны хуванцар савны ариун цэвэр, эрүүл ахуйн байдлын талаар тандан судалгаа явуулж дүнг нийтэд мэдээлэх;	Судалгаа	Судалгааны үр дүнг нийтэд мэдээлэх хэлэлцүүлэг зохион байгуулсан байх	ХХААХҮЯ	ШУТИС, НЭМХ,	2017-2021	Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж байгаа картонон хайрцаг, нэг удаагийн хэрэглээний хэрэгсэл болон ус, ундааны хуванцар савны ариун цэвэр, эрүүл ахуйн байдлын талаар тандан судалгааг 2019 онд хийхээр төлөвлөж байна. Судалгааг НЭМҮТ-өөр гүйцэтгүүлнэ.	40
4	эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах зориулалтын хөргөлттэй вагон, үр тарианы контейнер, автогээврийн хэрэгсэл, агуулах, зоорь, хөргүүрийн камерын хангамжийг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг чиглүүлж өргөжүүлэх;	Зориулалтын тээврийн хэрэгсэл, агуулах, зоорь	Зориулалтын тээврийн хэрэгсэл, агуулах, зоорийн хангамж нэмэгдсэн байх	ХХААХҮЯ, ЗТХЯ	ААН, ТББ	2017-2021	Хөгжлийн банкны дэргэд “DBM лизинг” ХХК шинээр үүсгэн байгуулагдсантай холбогдуулан хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийг импортын санхүүжилтын хөнгөлөлттэй нөхцлөөр хангах талаар судалгаа хийж байна. Энэ ажлын хүрээнд МҮХАҮТ, Монголын хүнсчдийн холбоонд хандаж хувийн хэвшилд шаардлагатай байгаа хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагын талаар судалгаа ирүүлэх албан бичгийг хүргүүлээд байна. “Хүнсний аюулгүй байдал ба хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт” хэлэлцүүлгийг 2019 онд Монголын хүнсчдийн холбоо, “DBM лизинг” ХХК, Монголын автомашин импорлогч дистрибьютерүүдийн холбоотой хамтран зохион байгуулахаар хөтөлбөрийг боловсруулав.	40
5	түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодлын уян хатан, бат бөх чанар, найрлагыг судлах, тэмдэглэгээг баталгаажуулах, чанар, эрүүл ахуйн үнэлгээ хийх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах;	Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	Лабораторийн чадавхи бэхжиж, шинжилгээний төрөл нэмэгдсэн байх	ХХААХҮЯ	МХЕГ, ШУТИС	2017-2021	Хүнсний зориулалтын болон зориулалтын бус хуванцар савны материалыг шинжлэх, гарал үүслийг тогтоох, олон улсын тэмдэглэгээний дагуу ангилах чиглэлд лабораториудын ажлын уулзалтыг 2017 оны 11 дүгээр сарын 03-нд зохион байгуулав. Уулзалтад МХЕГ-ын ХАБҮЛЛ, НЭМҮТ-ийн Хор судлал, орчны шинжилгээний төв, ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэн, АШУҮИС, “САМО” институт, ШУТИС, ГТЛ-ийн төлөөлөл оролцож, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал солилцов. Энэ арга хэмжээний дүнд “Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” төслийн баримт бичгийг боловсруулав. Тус төслийн баримт бичгийг дараах 3 зорилтын хүрээнд боловсруулсан.	40

							<p>1. <i>Лабораториудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;</i></p> <p>2. <i>Лабораториудад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлэх;</i></p> <p>3. <i>Лабораториудад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлэх.</i></p> <p><i>Дээрх төсөлд олон улсын байгууллагуудаас дэмжлэг авч хамтран хэрэгжүүлнэ гэж үзэж байна.</i></p>	
6	хүнсний зориулалтын сав, баглаа боодлын лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэн, ажилтнуудыг чадавхжуулах зэрэг арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;	Нийлүүлсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалт	Нийлүүлсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо, сургалтад хамрагдсан хүний тоо	ХХААХҮЯ	ШУТИС, МХЕГ	2017-2021	Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” төслийг хамтран хэрэгжүүлэх саналыг 2018 оны 1 дүгээр сард зохион байгуулсан Монгол Улс, БНСУ-ын Хөдөө аж ахуйн хамтарсан хорооны 7 дугаар хурлаар Солонгосын талд тавьсан.	40
7	хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээлэл болон сэрэмжлүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх, сурталчлах;	Мэдээлэл, зөвлөмж, сурталчилгаа	Хэрэглэгчдийн мэдлэг дээшилсэн байх	ЭМЯ, МХЕГ, ШӨХТГ, ТББ	Олон нийтийн мэдээллийн байгууллага	2017-2021	<p>ХХААХҮЯ-наас 2017 оны 6 дугаар сарын 9-10-нд зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээний үеэр хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, зориулалтын савны ач холбогдлын талаарх сурталчилгааны зөвлөмж материал 1000 хувь хэвлүүлж, хэрэглэгчдэд тарааж сурталчлав. Өдөрлөгийн үеэр тогтоосон хуваарийн дагуу мэдээллийн буланд ажиллаж олон нийтэд мэдээлэл хүргэв. Монголын үндэсний олон нийтийн радиогийн шууд нэвтрүүлэгт 2017 оны 11 дүгээр сарын 15-нд оролцож, хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг зогсоох, зориулалтын савны хэрэглээг дэмжих асуудлаар олон нийтэд мэдээлэл хийв.</p> <p>“Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулах талаар ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2017-2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгуулсан. Тус ажлын хүрээнд орон нутагт хөх савны хор хөнөөл, хүнсний зориулалтын савны хэрэглээний талаар орон нутагт нийт 88 удаагийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, 15 мянга гаруй хүнийг хамруулан, сурталчилгааны материал тараасан байна.</p> <p>Хүнсний зориулалтын бус хуванцар савны хор нөлөөг олон нийтийн анхаарлын төвд оруулах, сав, баглаа</p>	100

						<p>боодлын салбарыг сурталчлах, бэхжүүлэх зорилгоор “Сав, баглаа боодлын өдөр”-тэй болох зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал авч нэгтгэн 2018 оны 3 дугаар сард, мөн 7 дугаар сард ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч ХЗДХЯ-наас дэмжих боломжгүй гэсэн санал ирүүлсэн үндэслэлээр буцаасан.</p> <p>Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар Монгол Улсын сав, баглаа боодол үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн анхдугаар зөвлөлдөх уулзалт-2018 болон сав, баглаа боодлын салбарын оны шагнал “Мөнгөн богц” гардуулах арга хэмжээний үеэр хэвлэлийнхэнд хандаж мэдээлэл хүргэсэн. Мөн сав, баглаа боодлын үйлдвэрлэл, хэрэглээний асуудлаар ТВ-8, “V” ТВ, Монголын радиогийн нэвтрүүлгүүдэд оролцож ярилцлага, мэдээлэл өгөв.</p>		
8	хүний эрүүл мэндэд хортой, сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон хүнсний зориулалтын бус сав, баглаа боодол, хэрэгслийг хүнсний худалдаа, үйлчилгээ, нийтийн хоол, сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг зэрэг газар хэрэглэхийг хориглох, өрхийн хэрэглээнээс халах арга хэмжээ авах;	Уриалга, зөвлөмж	Зориулалтын бус савны хэрэглээ буурсан байх	ЭМЯ, МХЕГ, ШӨХТГ, ТББ	ХХААХҮЯ	2017-2021	<p>“Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулах талаар ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгуулсан. Тус ажлын хүрээнд орон нутагт дараах онцлох ажлууд хийгдсэн:</p> <ul style="list-style-type: none"> - Говь-Алтай аймагт хүнсний зориулалтын бус хуванцар хөх савны хэрэглээг сургууль, цэцэрлэгүүдэд бүрэн халсан. - Хэнтий аймагт 24 худаг, уст цэг болон хүнсний 120 дэлгүүрийн мэдээллийн самбарт “Хүнсний зориулалтын сав” түүний ач холбогдлын талаар танилцуулга, мэдээлэл байршуулж, олон нийтэд сурталчилсан. - Өвөрхангай аймгийн бүх суманд төсөвт байгууллагуудад хүнсний зориулалтын бус савыг хүнсэнд хэрэглэхээс татгалзаж хэвшсэн. - Завхан аймагт хуванцар савны худалдаа эрхлэгчдэд “Хуванцар савны эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээ” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ арга хэмжээний дүнд тус аймгийн зах зээлд хөх савны нийлүүлэлт 50 хувиар буурсан. - Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн үйлчилгээний газруудын гал тогоонд зориулалтын сав, суулга хэрэглэж хэвшсэн. 	100

							<p>- Төв аймгийн хэмжээнд судалгаа хийж, нийт 29 мянган өрхийн 60 хувь нь хүнсний зориулалтын бус сав хэрэглэж байна гэсэн дүн гарсан. Тус аймгийн 27 суманд сургалт зохион байгуулж 5890 өрхийг хамруулан, 3900 ширхэг гарын авлагаар хангасан. Нийслэлийн Хан-Уул дүүргээс “Эко дүүрэг” санаачилга дэвшүүлсэнтэй холбогдуулан тус дүүргийн ЗДТГ-аас хороодынхоо дунд 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцож Сав, баглаа боодлын талаар төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийж, санал солилцов.</p>	
9	<p>хүнсний зах, худалдааны төв, үйлдвэр, үйлчилгээний газруудыг эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын тор, бидон, зориулалтын сав, баглаа боодол, агуулах, хөргүүр ашиглахыг шаардах, зөв дадлыг хэвшүүлэх;</p>	Шаардлага		ЭМЯ, МХЕГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2021	<p>“Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулах талаар ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгуулсан. Тус ажлын хүрээнд орон нутагт дараах онцлох ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <p>- Хөх савны хор хөнөөл, хүнсний зориулалтын савны хэрэглээний талаар орон нутагт нийт 88 удаагийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, 15 мянга гаруй хүнийг хамруулан, сурталчилгааны материал тараасан.</p> <p>- Сүхбаатар аймагт “Аргил сувд” ХХК-иас 1300 ширхэг усны эко сав татан авч, Баруун-Урт сумын 400 гаруй иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулсан.</p> <p>- Говь-Алтай аймагт хүнсний зориулалтын бус хуванцар хөх савны хэрэглээг сургууль, цэцэрлэгүүдэд бүрэн халсан.</p> <p>- Хэнтий аймагт 24 худаг, уст цэг болон хүнсний 120 дэлгүүрийн мэдээллийн самбарт “Хүнсний зориулалтын сав” түүний ач холбогдлын талаар танилцуулга, мэдээлэл байршуулж, олон нийтэд сурталчилсан.</p> <p>- Өмнөговь аймагт орон нутгийн төсвийн хүрээнд эко савалгаа нэвтрүүлэхэд нь зориулж “Задаг” ХХК-нд 10 сая, “Ингэний сүүн чихэр” үйлдвэрлэлд 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Өвөрхангай аймгийн бүх суманд төсөвт байгууллагуудад хүнсний зориулалтын бус савыг хүнсэнд хэрэглэхээс татгалзаж хэвшсэн.</p>	100

							<p>- Завхан аймагт хуванцар савны худалдаа эрхлэгчдэд “Хуванцар савны эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээ” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ арга хэмжээний дүнд тус аймгийн зах зээлд хөх савны нийлүүлэлт 50 хувиар буурсан.</p> <p>- Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн үйлчилгээний газруудын гал тогоонд зориулалтын сав, суулга хэрэглэж хэвшсэн.</p> <p>- Төв аймгийн хэмжээнд судалгаа хийж, нийт 29 мянган өрхийн 60 хувь нь хүнсний зориулалтын бус сав хэрэглэж байна гэсэн дүн гарсан. Тус аймгийн 27 суманд сургалт зохион байгуулж 5890 өрхийг хамруулан, 3900 ширхэг гарын авлагаар хангасан.</p> <p>Аймгуудын ХХААГ-ын хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан 2018 оны 6 дугаар сарын 13-нд ХХААХҮЯ-нд зохион байгуулсан семинарын үеэр “Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөнийг эрчимжүүлэх, гарч байгаа ололт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн. Хөх сав, канистергүй аймаг, сум хөдөлгөөнийг орон нутагт үргэлжүүлэн зохион байгуулж байна.</p>	
10	химийн бодисын хуванцар сав, торх, канистерыг хүнсний зориулалтаар ашиглуулахгүй байх зорилгоор “Шинэ санаа-шилдэг шийдэл” уралдаан зарлаж, дүнг нийтэд сурталчлах, түгээх;	“Шинэ санаа-шилдэг шийдэл” уралдаан	Уралдааныг дүгнэж, нийтэд сурталчилсан байх	ХХААХҮЯ, ЭМЯ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2021	“Шинэ санаа-шилдэг шийдэл” уралдааныг ХХААХҮ-ийн сайдын ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-160 дугаар тушаалаар удирдамж батлуулж зарласан. Уралдаанд ирүүлсэн бүтээлүүд удирдамжид заасан шалгуур, шаардлагыг хангаагүй гэж дүгнэсэн. Уралдааны цар хүрээг өргөтгөн орон нутгийн захиргааны байгууллагуудаар уламжлан улсын хэмжээнд зохион байгуулах зүйтэй гэж үзсэн.	70
11	хүнс үйлдвэрлэгчдэд хаяг шошгын стандарт мөрдүүлж хэвшүүлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэхээс сэргийлэх зорилгоор сурталчилгааны арга хэмжээ авах;	Сурталчилгаа,	Стандартын мөрдөлтийн хувь	СХЗГ, МХЕГ, ШӨХТГ	ХХААХҮЯ, ТББ	2017-2021	Стандарт, хэмжил зүйн газраас “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648:2016” стандартыг баталсан. Тус стандартыг 2017 оны 7 дугаар сарын 01-нээс мөрдөж эхлэх байсан. Хүнсний боловсруулах салбарын аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, хүсэлтийг харгалзан СХЗГ-аас дээрх стандартыг мөрдөж эхлэх хугацааг 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл сунгасан. Энэ асуудалтай холбогдуулан тус стандартын талаар гишүүн байгууллагууддаа мэдээлэл	70

							хүргэж, стандарт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах талаар хүнсний салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод албан бичиг хүргүүлсэн. Стандартын 2018 оны улсын үзлэгийн хүрээнд үйлдвэрлэл, хаяг шошго, техникийн зохицуулалтын стандартыг дахин хянах, олон улсын түвшинд хүргэх, шинээр батлуулах стандартын саналыг боловсруулах ажлыг зохион байгуулж, одоо мөрдөгдөж буй нийт 62 стандартыг хянасан. Мөн “Хүнсний зориулалтын хуванцар сав” стандартуудын төслийг шинээр боловсруулсан. Стандартуудыг 2019 онд батлуулна.	
12	зөв шошготой, чанар, стандартын шаардлага хангасан сав, баглаа боодлын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хүргэх ажлыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;	Мэдээллийн сан	Мэдээллийн сан бүрдсэн байх	ХХААХҮЯ	ТББ	2017-2021	Мэдээллийн санг бүрдүүлэх арга хэмжээний талаар судалж байна.	0
13	хүнсний зориулалтын бус хуванцар сав, гялгар уутны хэрэглээнээс татгалзах аян өрнүүлэх, “Хөх сав, канистергүй аймаг, дүүрэг, сум, хороо” хөдөлгөөн өрнүүлж, жил бүр дүгнэж мэдээлдэг болох;	“Хөх сав, канистергүй аймаг, дүүрэг, сум, хороо” хөдөлгөөн	Хөдөлгөөний арга хэмжээг дүгнэж, нийтэд сурталчилсан байх	ЭМЯ, ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2021	<p>“Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулах талаар ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгуулсан. Тус ажлын хүрээнд орон нутагт дараах онцлох ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөх савны хор хөнөөл, хүнсний зориулалтын савны хэрэглээний талаар орон нутагт нийт 88 удаагийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, 15 мянга гаруй хүнийг хамруулан, сурталчилгааны материал тараасан. - Сүхбаатар аймагт “Аргил сувд” ХХК-иас 1300 ширхэг усны эко сав татан авч, Баруун-Урт сумын 400 гаруй иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулсан. - Говь-Алтай аймагт хүнсний зориулалтын бус хуванцар хөх савны хэрэглээг сургууль, цэцэрлэгүүдэд бүрэн халсан. 	100

							<p>- Хэнтий аймагт 24 худаг, уст цэг болон хүнсний 120 дэлгүүрийн мэдээллийн самбарт “Хүнсний зориулалтын сав” түүний ач холбогдлын талаар танилцуулга, мэдээлэл байршуулж, олон нийтэд сурталчилсан.</p> <p>- Өмнөговь аймагт орон нутгийн төсвийн хүрээнд эко савалгаа нэвтрүүлэхэд нь зориулж “Задат” ХХК-нд 10 сая, “Ингэний сүүн чихэр” үйлдвэрлэлд 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Өвөрхангай аймгийн бүх суманд төсөвт байгууллагуудад хүнсний зориулалтын бус савыг хүнсэнд хэрэглэхээс татгалзаж хэвшсэн.</p> <p>- Завхан аймагт хуванцар савны худалдаа эрхлэгчдэд “Хуванцар савны эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээ” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ арга хэмжээний дүнд тус аймгийн зах зээлд хөх савны нийлүүлэлт 50 хувиар буурсан.</p> <p>- Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн үйлчилгээний газруудын гал тогоонд зориулалтын сав, суулга хэрэглэж хэвшсэн.</p> <p>- Төв аймгийн хэмжээнд судалгаа хийж, нийт 29 мянган өрхийн 60 хувь нь хүнсний зориулалтын бус сав хэрэглэж байна гэсэн дүн гарсан. Тус аймгийн 27 суманд сургалт зохион байгуулж 5890 өрхийг хамруулан, 3900 ширхэг гарын авлагаар хангасан.</p> <p>Аймгуудын ХХААГ-ын хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан 2018 оны 6 дугаар сарын 13-нд ХХААХҮЯ-нд зохион байгуулсан семинарын үеэр “Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөнийг эрчимжүүлэх, гарч байгаа ололт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн. Хөх сав, канистергүй аймаг, сум хөдөлгөөнийг орон нутагт үргэлжүүлэн зохион байгуулж байна.</p>	
14	хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээг хэрэглээнд хэвшүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд	Сурталчилгаа	нийтэд сурталчилсан тоо	ХХААХҮЯ	ТББ	2017-2021	Монголын үндэсний олон нийтийн радиогийн шууд нэвтрүүлэгт 2017 оны 11 дүгээр сарын 15-нд оролцож, хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг зогсоох, зориулалтын савны хэрэглээг дэмжих асуудлаар олон нийтэд мэдээлэл хийв. Мөн “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн олон улсын зөвлөлдөх уулзалтын үеэр сэтгүүлчдэд хуванцар савны хэрэглээний талаар мэдээлэл хийв.	100

	сурталчлан таниулах арга хэмжээ авах;						Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар Монгол Улсын сав, баглаа боодол үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн анхдугаар зөвлөлдөх уулзалт-2018 болон сав, баглаа боодлын салбарын оны шагнал “Мөнгөн богц” гардуулах арга хэмжээний үеэр хэвлэлийнхэнд хандаж мэдээлэл хүргэсэн. Мөн “V” ТВ, Монголын радиогийн нэвтрүүлэгт оролцож мэдээлэл өгөв.	
15	хүнсний чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан сав, баглаа боодлын эрүүл ахуй, чанар стандарт, аюулгүй байдлын талаар тусгайлан сургалт зохион байгуулах;	Сургалт	Зохион байгуулсан сургалт, түүнд хамрагдсан хүний тоо	МХЕГ, СХЗГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2021	МҮХАҮТ-ын дэргэдэх Сав, баглаа боодлын зөвлөлтэй хамтран сав, баглаа боодол үйлдвэрлэгчид, хуванцар дахин боловсруулагчид, хүнсний үйлдвэрүүдэд зориулсан сургалт, хэлэлцүүлгийг 2018 оны 6 дугаар сарын 20-нд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дотоодын 60 гаруй аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдсан.	100
16	хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн зөөвөрлөх, хадгалахад ашиглаж байгаа зориулалтын бус савыг зориулалтын саваар солих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	Арга хэмжээ	зориулалтын бус савыг зориулалтын саваар сольсон тоо	ТББ	Аймаг, нийслэлийн ХХААГ,	2017-2021	“Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав” гэсэн төслийн баримт бичгийг боловсруулсан. Эдгээр төслийг “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн олон улсын зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын хөтөлбөр, төслийн байгууллагуудад танилцуулсан. Эдгээр төслийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлснээр гэр хорооллын айл өрхүүд худгаас ундны ус зөөвөрлөж, хадгалж байгаа болон хөдөөгийн малчин өрхүүд сүү, цагаан идээгээ бэлтгэж байгаа хүнсний зориулалтын бус хуванцар савыг үе шаттай солих нөхцөл, боломж бүрдэнэ.	0
Зорилт 3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх								
1	хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, шинэ технологи бүхий сав, баглаа боодлын эко үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжих;	Сав баглаа боодлын эко үйлдвэр	Сав баглаа боодлын эко үйлдвэрийг дэмжисэн байх	ХХААХҮЯ, ЖДҮХС	ААН, Олон улсын байгууллага	2017-2021	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй “эко бүтээгдэхүүн”, эрүүл хүнс цагаан идээ зэрэг хүнсний зориулалттай төрөл бүрийн модон сав үйлдвэрлэх талаар “ТЭББЭ”ХХК-иас ирүүлсэн төслийг бодлогоор дэмжиж, хөнгөлөлттэй зээлд хамруулахаар ЖДҮХС-д хүргүүлсэн. Сав, баглаа боодлын салбарт хөнгөлөлттэй санхүүжилт татах зорилгоор Хөгжлийн банкны холбогдох албан тушаалтнуудтай 2018 оны 2 дугаар сард уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар сав, баглаа боодлын салбарын өнөөгийн байдал, тус	0

							салбарт хэрэгжүүлэх төсөл, санхүүгийн хэрэгцээ, шаардлагын талаар ярилцаж, санал, мэдээлэл солилцсон. Уулзалтын үр дүнд Хөгжлийн банкнаас сав, баглаа боодлын салбарыг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн бөгөөд Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбооноос сав, баглаа боодлын салбарт хэрэгжүүлэх кластер төслийн саналыг боловсруулахаар тогтсон.	
2	уламжлалт модон торх, ган, хувин, ширэн хөхүүр, гоёл чимэглэлийн уут, савны урлалыг дэмжиж брэнд болгох ажлыг орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулах, даавуун болон цаасан тор, уутны хэрэглээг дэмжих;		даавуун болон цаасан тор, уутны үйлдвэрлэл нэмэгдсэн байх	Аймаг, нийслэлийн ЗДТГ	ТББ, ААН, Олон улсын байгууллага	2017-2021	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн олон улсын зөвлөлдөх уулзалтын үеэр дотоодын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэнг зохион байгуулсан. Тус үзэсгэлэнд модон сав, айрагны хөхүүр, зэс, гуулин сав суулга, аяга, халбага, цаасан хайрцаг, ороогч, багцлагч, хүнсний зориулалтын сав, гялгар уут үйлдвэрлэгч дотоодын 10 гаруй аж ахуйн нэгж оролцож, бүтээгдэхүүнээ танилцуулсан. Уламжлалт модон торх үйлдвэрлэгч “ТЭББЭ” ХХК-ийн үйл ажиллагаа, брэнд бүтээгдэхүүний талаар нэвтрүүлэг хийж, “Сүлд” ТВ-ээр олон нийтэд 2 удаагийн цацалт хийсэн. Үндэсний уламжлалт сав баглаа болох ширэн хөхүүр, модон хувингийн стандарт боловсруулах санал боловсруулж СХЗГ-т хүргүүлэв. Стандартын төслүүдийг 2019 онд батлуулна.	40
3	Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд чанар, стандарт, загвар дизайны шаардлага хангасан дотоодын сав, баглаа боодол, хаяг шошго хэрэглэхийг төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд уриалж, энэ чиглэлээр явуулж байгаа сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	Уриалга, сурталчилгаа	дотоодын сав, баглаа боодол, хаяг шошго үйлдвэрлэлийн хэмжээ өссөн байх	ХХААХҮЯ	ТББ, ААН, Олон улсын байгууллага	2017-2021	“Намрын ногоон өдрүүд-2017” нэгдсэн арга хэмжээний “Эрүүл Монгол хүнс” үзэсгэлэн худалдаанд “Дэвшилтэт савлагаатай хүнсний бүтээгдэхүүн” номинацийн шалгаруулалтыг зохион байгуулсан. Тус шалгаруулалтад “Хаш хүнс трейд” ХХК-ийн “элэгний нухаш” бүтээгдэхүүн дэвшилтэт савлагаатайгаар шалгарсан. “Хүнсний аюулгүй байдлын цаг” нэвтрүүлгийг МҮОНРТ-тай хамтран уламжлал болгон бэлтгэхээр ажиллаж байна. Энэ нэвтрүүлгийн зорилго, агуулга, хөтөлбөрийг 2018 онд гаргаж МҮОНРТ-д хүргүүлэв.	0

4	Монгол Улсад үйлдвэрлэх боломжтой сав, баглаа боодлын нэр, төрөл, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа явуулах, сав, баглаа боодлын үндсэн түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих, цаас, шил, төмөр сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, арга замыг судалж шийдвэрлэх;	Судалгаа	дотооддоо үйлдвэрлэх боломжтой сав баглаа боодлын нэр төрөл тодорхой болж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам шийдвэрлэгдсэн байх	ХХААХҮЯ	ТББ, ААН	2017-2021	Даацын шуудай, сав баглаа боодол үйлдвэрлэгч дотоодын 7 үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, тэдгээрийн суурилагдсан хүчин чадал, хүчин чадлын ашиглалт, мөн хэрэгцээний харьцуулсан судалгааг гаргав. Дотоодын сав, баглаа боодлын үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл, байдлын шинжилгээг 2017 онд хийж гүйцэтгэсэн. Засгийн газрын “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн 4.5.9-д “Сав, баглаа боодлын захиалгын болон худалдааны цэгийг байгуулж ажиллуулах” заалтыг тусгасан. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд шил үйлдвэрлэх төслийг Хөгжлийн банкинд танилцуулсныг 2019 онд тус банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.	0
5	сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, бусад салбартай хоршин ажиллах боломжийг тодорхойлох үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой байгуулж үйл ажиллагааг нь дэмжих;	Мэргэжлийн зөвлөл	Мэргэжлийн зөвлөл байгуулагдсан байх	ХХААХҮЯ	ТББ, ААН	2017-2021	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах чиг үүрэгтэй орон тооны бус Үндэсний зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тус зөвлөлийн ажиллах журмыг ХХААХҮ-ийн сайдын А-54 дүгээр тушаалаар баталсан. Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоотой хамтран хүнд даацын сав баглаа үйлдвэрлэгчидтэй уулзалт зохион байгуулав. Уулзалтад хүнд даацын сав, баглаа үйлдвэрлэгчид төрийн худалдан авалтад нэгдсэн зохион байгуулалттай, кластер хэлбэрээр оролцох асуудлаар ярилцаж, санал, мэдээлэл солилцсон.	100
6	олон улсын сав, баглаа боодлын холбоонд гишүүнээр элсэх боломжийг судалж шийдвэрлэх;	Судалгаа	Судалгаанд үндэслэн санал боловсруулж шийдвэрлүүлсэн байх	ХХААХҮЯ, ГХЯ	ТББ	2017-2021	Дэлхийн сав, баглаа боодлын байгууллага /World Packaging Organization/-ын талаар судалсан. Тус байгууллагад гишүүнээр элсүүлэх асуудлаар Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоотой уулзалт зохион байгуулсан. Тус холбоог Дэлхийн сав, баглаа боодлын холбоонд 2019 онд гишүүнээр элсүүлнэ. Дэлхийн сав, баглаа боодлын	40

							холбоотой холбоо тогтоосон бөгөөд 2019 онд 4 чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна.	
7	дотоодын сав, баглаа боодол, хаяг шошгыг тогтмол хэрэглэгч, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжүүдийг жил бүр шалгаруулж урамшуулдаг болох	Шалгаруулалт	Шалгарсан аж ахуйн нэгжид үзүүлсэн урамшуулал	ХХААХҮЯ	ТББ, ААН	2017-2021	Монгол Улсын сав, баглаа боодол үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав. Сав, баглаа боодлын салбарын оны шагнал болох “Мөнгөн богц” арга хэмжээг санаачилж, тус зөвлөлдөх уулзалтын үеэр хүнс, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоол, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын тус бүр 1, нийт 5 аж ахуйн нэгжийг шагнав. Монгол Улсын дотоодын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн каталогийг хамтран боловсруулж 1000 ш хэвлүүлэн, түгээж байна.	100